



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Баян-уул суман дахь Сум дундын ойн ангийн
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/15/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: У.Энхчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	17



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.09 № 272
танай _____-ны № _____-г

БАЯН-УУЛ СУМАН ДАХЬ
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Г.ГАНБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-уул суман дахь сум дундын ойн ангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-уул суман дахь сум дундын ойн ангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-уул суман дахь сум дундын ойн ангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520293



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

“Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги” -ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Ганбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги” -ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги” -ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дүгээр сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 04-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын захиалгаар “Хаан консалтинг аудит” ХХК-ийн аудитор У.Энхчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

“Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги” -ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги”-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

“Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги”-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ойн нөөцийг ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах, мод үржүүлэг, ойжуулалт.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги”-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги” нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ахplorer программ хангамж ашигладаг байна.

“Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд бага эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 93,761.5 мянган төгрөгөөс тооцон 1,875.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг мөн 1,8756.2 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,297.76 мянган төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	22,179.45	50,962.62	28,783.17
Үндсэн хөрөнгө	250,004.80	278,313.92	28,309.13
Хуримтлагдсан элэгдэл	(35,495.13)	(65,289.67)	(29,794.54)
Нийт хөрөнгө	236,689.11	263,986.88	27,297.76
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	236,689.11	263,986.88	27,297.76
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	236,689.11	263,986.88	27,297.76

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд орон нутгийн өмчийн хөрөнгөөр Бавж барас ХХК 50 га талбайд 30,200,000 төгрөгийн өртөгтэй ойжуулалт хийж хүлээлгэн өгснийг бараа материалын дансанд бүртгэснээс шалтгаалжээ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь БОАЖГ-ын Байгал хамгаалах сангийн зардлаар баригдсан 23,475,915 төгрөгийн нөхөрлөлүүдийн байр, Ойн мэдээллийн төвийн сургалтын танхимд зориулж 2,597,255 төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус шилжүүлж өгсөн нь шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 340.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан мянган төгрөгийн 2,370.0 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 2,837.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 263,986.88 мянган төгрөг болж 27,297.76 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын өсөлтөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар “Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги” тайлант онд 46,995.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 46,995.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 46,995.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 46,995.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 46,995.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 46,995.5 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14,608.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 11,800.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,808.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 28 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 18,994.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3,551.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 232.7 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 15,209.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 18,994.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 15,442.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Жолоочийн тооцооны хуудсан дээр автомашинаар зорчсон ажилтны гарын үсэггүй, иж бүрэн бус баримтаар тооцоо бодож 232.7 мянган төгрөгийг зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалттай нийцэхгүй, бодитой ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. 2019 онд нийт 18,055,400 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авснаас 11,685,644 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ е-баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад "анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

3. Шатахууны зарцуулалтын баримтыг шалгаж үзэхэд 4,120,971 төгрөгийн шатахуун худалдан авсан байна. 2019 оны 4-12 сарын жолоочийн тооцооны хуудсан дээр явсан км-ын заалт болон машины спидометрийн заалтыг бичээгүй, тооцоо бодсон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4 дахь хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг

бүртгэхгүй байх гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 200.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Шатахууны зарцуулалтын тооцоог авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

“Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги” Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 420.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 420.0 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “ Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги” -ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Баян-Уул суман дахь Сум дундын ойн анги” -ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ашиглалтгүй, үлдэх өртөггүй архивын программ хангамжийг данснаас хасаагүй байна.

1.2. Эрсдэл:

Ашиглалтгүй хөрөнгийг бүртгэх нь хөрөнгийн дүнг бодит бусаар нэмэгдүүлэх эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж:

Акталж данснаас хасах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,179,447.32	50,962,620.32
35	БАРАА МАТЕРИАЛ	22,179,447.32	50,962,620.32
351	Түүхий эд материал	1,744,920.00	298,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,744,920.00	298,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	7,528,680.00	37,728,680.00
354	Хангамжийн материал	12,905,847.32	12,935,940.32
35410	Бичиг хэргийн материал	292,700.00	680,490.00
35420	Аж ахуйн материал	11,068,797.32	10,696,100.32
35450	Барилгын засварын материал	1,499,350.00	1,499,350.00
35470	Бусад хангамжийн материал	45,000.00	60,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	214,509,665.28	213,024,256.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	214,509,665.28	213,024,256.36
392	Биет хөрөнгө	140,732,165.32	139,439,256.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	63,479,122.22	86,812,816.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,794,875.00	36,794,875.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,318,833.17)	(9,341,312.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,666,817.11	63,593,850.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,089,494.05)	(35,097,495.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,065,000.00	7,113,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(765,000.08)	(1,315,000.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,828,982.80	9,828,982.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,929,304.51)	(6,736,845.59)
393	Биет бус хөрөнгө	73,777,499.96	73,584,999.92
39301	Програм хангамж	970,000.00	970,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(392,500.04)	(585,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	73,200,000.00	73,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	236,689,112.60	263,986,876.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	236,689,112.60	263,986,876.68
51	Засгийн газрын хувь оролцоо	236,689,112.60	263,986,876.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	102,590,325.00	102,590,325.00
51101	Өмч: - төрийн	102,590,325.00	102,590,325.00
512	Хуримтлагдсан үр дүн	120,482,058.89	144,512,492.41
51210	Өмнөх үеийн үр дүн	120,482,058.89	120,624,280.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,616,728.71	16,884,059.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	236,689,112.60	263,986,876.68

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	144,309,935.57	117,649,795.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,315,935.57	56,045,915.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,753,748.21	56,045,915.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,753,748.21	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,753,748.21	-
121	Хөрөнгийн орлого	76,562,187.36	-
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	76,562,187.36	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,994,000.00	61,603,880.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,927,000.00	14,608,380.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,239,500.00	11,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,687,500.00	3,608,380.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,067,000.00	46,995,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,067,000.00	46,995,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	80,521,082.52	90,352,030.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,521,082.52	90,352,030.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,520,482.52	87,022,190.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,091,400.00	33,168,201.00
210101	Үндсэн цалин	31,111,400.00	33,168,201.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,980,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	3,665,600.00	4,326,599.00
210201	Тэтгэврийн даатгал	2,419,500.00	2,818,030.00
210202	Тэтгэмжийн даатгал	249,500.00	513,942.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	311,600.00	265,234.00
210204	Ажилгүйдлийн даатгал	62,300.00	66,307.00
210205	Эрүүл мэндийн даатгал	622,700.00	663,086.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	650,000.00	780,000.00
210301	Гэрэл, цахилгаан	215,582.00	148,683.00
210302	Түлш, халаалт	434,418.00	631,317.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,708,500.00	9,565,127.00
210401	Бичиг хэрэг	328,500.00	618,540.00
210402	Тээвэр, шатахуун	5,140,000.00	6,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	240,000.00	339,570.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	476,700.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	87,000.00	-
210604	Урсгал засвар	389,700.00	-
2107	Томилолт, зочны зардал	900,000.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	723,840.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,700.00	78,540.00
210807	Газрын төлбөр	45,300.00	45,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,728,282.52	36,458,423.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,549,550.00	3,826,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,178,732.52	32,631,723.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600.00	3,329,840.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	600.00	2,829,840.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	600.00	2,829,840.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	63,788,853.05	27,297,764.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	63,788,853.05	23,888,212.30

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	65,994,000.00	61,603,880.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,994,000.00	61,603,880.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,927,000.00	14,608,380.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,239,500.00	11,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,687,500.00	3,608,380.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,067,000.00	46,995,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,067,000.00	46,995,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	65,994,000.00	61,603,880.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,994,000.00	61,603,880.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,993,400.00	58,274,040.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,091,400.00	33,477,500.00
210101	Үндсэн цалин	31,111,400.00	33,477,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,980,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,665,600.00	4,017,300.00
210201	Тэтгэврийн даатгал	2,419,500.00	2,678,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	249,500.00	267,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	311,600.00	334,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	62,300.00	67,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	622,700.00	669,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	601,700.00	780,000.00
210301	Гэрэл, цахилгаан	228,702.00	148,683.00
210302	Түлш, халаалт	372,998.00	631,317.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,740,000.00	7,375,400.00
210401	Бичиг хэрэг	360,000.00	695,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,140,000.00	6,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	240,000.00	360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,317,700.00	5,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	-
210604	Урсгал засвар	3,217,700.00	5,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	900,000.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	723,840.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,700.00	78,540.00
210807	Газрын төлбөр	45,300.00	45,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,377,000.00	4,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,377,000.00	4,400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600.00	3,329,840.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	600.00	2,829,840.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	600.00	2,829,840.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дун	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	102,590,325.00	13,616,728.71	120,482,058.89	0.00	236,689,112.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	102,590,325.00	13,616,728.71	120,482,058.89	0.00	236,689,112.60
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	102,590,325.00	13,616,728.71	120,482,058.89	0.00	236,689,112.60
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	102,590,325.00	13,616,728.71	120,482,058.89	0.00	236,689,112.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	102,590,325.00	13,616,728.71	120,482,058.89	0.00	236,689,112.60
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	3,267,330.56	142,221.22	0.00	3,409,551.78
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	23,888,212.30	0.00	23,888,212.30
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	102,590,325.00	16,884,059.27	144,512,492.41	0.00	263,986,876.68

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,995,500.00	46,974,040.00
УРСГАЛ ЗАРДАЛ	46,995,500.00	46,974,040.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,495,500.00	46,474,040.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,477,500.00	33,477,500.00
Үндсэн цалин	33,477,500.00	33,477,500.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,017,300.00	4,017,300.00
Тэтгэврийн даатгал	2,678,800.00	2,678,200.00
Тэтгэмжийн даатгал	268,100.00	267,800.00
ҮОМШӨ-ний даатгал	334,600.00	334,800.00
Ажилгүйдлийн даатгал	66,500.00	67,000.00
Эрүүл мэндийн даатгал	669,300.00	669,500.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	780,000.00	780,000.00
Гэрэл, цахилгаан	180,000.00	148,683.00
Түлш, халаалт	600,000.00	631,317.00
Хангамж, бараа материалын зардал	5,275,400.00	5,275,400.00
Бичиг хэрэг	695,400.00	695,400.00
Тээвэр, шатахуун	4,100,000.00	4,100,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	360,000.00
Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
Урсгал засвар	500,000.00	500,000.00
Томилолт, зочны зардал	800,000.00	800,000.00
Дотоод албан томилолт	800,000.00	800,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	745,300.00	723,840.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	78,540.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	200,000.00
Газрын төлбөр	45,300.00	45,300.00
Бараа үйлчилгээний бусад зардал	900,000.00	900,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	900,000.00	900,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00
Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00
Нэг удаагийн гэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	-	14,608,380.00
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	14,608,380.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	11,800,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	11,800,000.00
Хангамж, бараа материалын зардал	-	2,100,000.00
Тээвэр, шатахуун	-	2,100,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,000,000.00
Тавилга	-	5,000,000.00
Томилолт, зочны зардал	-	1,200,000.00
Дотоод албан томилолт	-	1,200,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,500,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,500,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,808,380.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,808,380.00